

МОНГОЛ УЛС, АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ХАМТАРСАН МЭДЭГДЭЛ

Өнөөдөр Ерөнхийлөгч Н.Багабанди, Ерөнхийлөгч Ж.Буш нар ардчилсан хоёр орны хооронд хамтын үнэт зүйлс болон стратегийн нийтлэг эрх ашигт тулгуурласан хамтын ажиллагаа, иж бүрэн түншлэлийн шинэ эрин үеийг зарлан тунхаглав. Тэд 2004 оны 1-дүгээр сарын 31-ний өдөр байгуулсан Хамтарсан мэдэгдлийг хэрэгжүүлэх явцад хүрсэн үр дүнг сайшаан тэмдэглээд цаашид харилцан зөвлөлдөж, хамтран ажиллах тухай хэлэлцэв. Хоёр тал зөвлөлдөх уулзалтыг бүх түвшинд тогтмол хийж байхаар харилцан тохиров. Тэд ардчилсан хоёр орны харилцаа үргэлжлэн өргөжин бэхжиж байгаад сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлэв. Ерөнхийлөгч Н.Багабандийн айлчлал нь тус хоёр улс хоёр талын харилцаандаа болон ардчилалын өргөн хүрээтэй үйл хэрэгт харилцан оролцох талаар чухал ахиц дэвшилд хүрснийг илтгэн харуулж байна.

Америкийн Нэгдсэн Улс саяхан Монгол Улсад болж өнгөрсөн чөлөөт, шудрага сонгууль нь Монгол Улс ардчилалын төлөө эрс тууштай байгаагийн бас нэг илрэл болов хэмээн үзэж баяр хүргэв.

Монгол Улсын ардчилал, эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлийг АНУ тууштай дэмжиж байгааг Ерөнхийлөгч Ж.Буш илэрхийлээд Монгол Улс төлөвшсөн, тогтвортой ардчилсан улс болж, хувийн хэвшил давамгайлсан зах зээлийн эдийн засагтай болох чиглэлд олсон амжилт дэвшилд баяр хүргэв. Улс орны ололт амжилтыг нь урамшуулж, өөрчлөлт шинэчлэлийн бодлогыг эрчимтэй үргэлжлүүлэхэд түлхэц өгч, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах зорилго бүхий шинэлэг арга хэлбэр болох Мянганы сорилтын сангаас тусламж авах эрх олж авсанд Ерөнхийлөгч Н.Багабанди болон Монголын ард түмэнд баяр хүргэв. Ерөнхийлөгч Ж.Буш саяхан болсон сонгуулиар ардчилалын төлөө зориг эрмэлзлэл төгс байгаагаа илэрхийлсэн явдалд Монголын ард түмэнд баяр хүргээд сонгуулийн үйл явц Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу чөлөөтэй, шудрага, ил тодоор амжилттай өндөрлөнө гэдэгт итгэлтэй байгаагаа тэмдэглэв.

Хөрш орнуудтайгаа найрсаг харилцаа хөгжүүлж, бүс нутгийн болон олон улсын эдийн засаг, улс төр, аюулгүй байдлын чуулга уулзалтуудад идэвхитэй оролцогч, ардчилсан, аюулгүй байдлаа бүрэн хангасан, цэцэглэн хөгжиж буй Монгол Улс нь Ази дахь энх тайван, тогтвортой байдлыг хангахад чухал хүчин зүйл болно гэдэгт хоёр Ерөнхийлөгч санал нэг байв. Бүс нутгийн болон олон улсын эдийн засаг, санхүүгийн байгууллагуудад нэгдэн орох талаарх Монгол Улсын хүч чармайлтыг Америкийн Нэгдсэн Улс дэмжиж байна.

Түүнчлэн Ерөнхийлөгч Н.Багабанди, Ерөнхийлөгч Ж.Буш нар Солонгосын хойг дахь цөмийн хөтөлбөрийг байнгын, нэг бүрчилсэн, ил тод байх үндсэн дээр задлах явдлыг дэмжиж байгаагаа тэмдэглэв. Зүүн Хойд Азид итгэлцлийг цаашид бэхжүүлэх үүднээс олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөж, эрх зүйн үүрэг хүлээлгэсэн цөмийн зэвсгээс ангид статустай болох талаар Монгол Улсын тавьж буй хүч чармайлтыг Америкийн Нэгдсэн Улс тэмдэглэв.

Ерөнхийлөгч Ж.Буш олон улсын терроризмтэй тэмцэх Монгол Улсын шийдвэртэй байр суурийг талархан дэмжиж байгаа бөгөөд Афганистан болон Иракийг тогтворжуулах, сэргээн босгох үйл ажиллагаа, түүнчлэн Ирак дахь олон улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцох талаар Монгол Улс шийдвэр төгс байгааг өндрөөр үнэлэв. Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс хоёр нь олон улсын энхийг сахиулах хүч чармайлтад оруулах Монгол Улсын хувь нэмрийг ахиулах талаар цаашид хамтран ажиллахаар тохиров. Ерөнхийлөгч Ж.Буш Монгол Улсын хөгжлийн урт хугацааны зорилтуудтай уялдуулан техникийн туслалцаа үзүүлэхэд чиглэсэн хоёр талын хөтөлбөрүүдийг цаашид тууштай үргэлжлүүлэх талаар Америкийн Нэгдсэн Улс хүсэл эрмэлзлэл дүүрэн байгааг нотлов. Ерөнхийлөгч Н.Багабанди Монгол Улсыг урт хугацааны туршид дэмжиж, эдийн засгийн туслалцаа үзүүлж байгаад Америкийн Нэгдсэн Улсад гүн талархал илэрхийлэв. Иракт чөлөөт, ардчилсан нийгмийг байгуулах явдал нь Ойрхи Дорнодод ардчилал, энх тайван, тогтвортой байдлыг бий болгоход чухал ач холбогдолтойг хоёр Ерөнхийлөгч тэмдэглэж, энэхүү үйл явцад Нэгдсэн Үндэстний Байгууллага тэргүүлэх үүрэг гүйцэтгэх ёстой гэж үзэв.

Ерөнхийлөгч нар хоёр орны худалдаа, хөрөнгө оруулалтыг идэвхитэй хөгжүүлэх талаар тохиролцож, Ерөнхийлөгч Н.Багабандийн айлчлалын үеэр Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улсын хоорондын Худалдаа, Хөрөнгө оруулалтын Ерөнхий хэлэлцээрт гарын үсэг зурж буйг онцлон тэмдэглэв. Энэ нь хоёр орны хооронд эдийн засаг, худалдааны илүү ойр дөт харилцааг зохих ёсоор хөгжүүлэхэд тус дөхөм болно гэж найдаж байгаагаа Ерөнхийлөгч нар илэрхийлэв.

Хоёр Ерөнхийлөгч харилцан бие биенээ хүндэтгэх зарчим, эрх тэгш түншлэлд тулгуурласан Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улсын харилцаа нь хоёр орны үндэсний ашиг сонирхолд нийцэж байгааг хүлээн зөвшөөрч, энэхүү чухал харилцааг гүнзгийрүүлэн бэхжүүлэх, дэлхий дахинд эрх чөлөө, энх тайван, ардчилал, хөгжил цэцэглэлийг тогтоохын төлөө хамтран ажиллахаа илэрхийлэв.